The Second Biennial

CAMBRIDGE MONGOLIA FORUM

# WORLD PROBLEM, NOMAD SOLUTION

19-20 August 2024

Ulaanbaatar, Mongolia

Mongolia has undergone a remarkable transformation of its identity in the past century, moving from a nation burdened by shame related to its feudal and socialist histories, as well as its pastoral way of life, to a proud rediscovery of its heritage, rooted in the legacy of Chinggis Khan and nomadic traditions. This recent shift is evident through two significant developments that define the post-COVID era: the establishment of the Chinggis Khaan National Museum as the nation's premier cultural institution and the introduction of the annual Nomads World Cultural Festival, positioning the nation as a global hub for nomadic peoples and their civilisations.

However, Mongolia is not alone in celebrating its nomadic identity and heritage. Where does Mongolia stand compared to other nations, such as China, Russia, and Central Asian countries that are now equally, if not more, passionate about their nomadic heritage? This Forum provides a platform for discussing the foundations of Mongolia's new vision, assessing the claim that Chinggis Khan and nomadic civilisation not only offer solutions to Mongolia's challenges, but also hold significant relevance for the contemporary world grappling with existential issues ranging from warfare to climate change.

**ORGANISERS**:

Mongolia and Inner Asia Studies Unit (MIASU), University of Cambridge
Ministry of Culture, Sports, Tourism and Youth of Mongolia
International Institute for the Study of Nomadic Civilizations under the auspices of UNESCO (IISNC)
Institute for Mongolian Studies, National University of Mongolia
The Chinggis Khaan Heritage and Cultural Institute

Citi University, Mongolia
National Art Gallery of Mongolia

**ORGANISING COMMITTEE:**

Prof. Uradyn E. Bulag, Research Director, MIASU, University of Cambridge
Prof. Bum-Ochir Dulam, Member of Parliament, Mongolia
Prof. Byambabaatar Ichinhorloo, Academic Secretary, Institute for Mongolian Studies, National University of Mongolia
Dr. Munkhtuul Chuluunbaatar, Director, International Institute for the Study of Nomadic Civilizations under the auspices of UNESCO (IISNC)
Dr. Saruul Nasanbuyan, Director, The Chinggis Khaan Heritage and Cultural Institute

COORDINATING ORGANISATION:
International Institute for the Study of Nomadic Civilizations under the auspices of UNESCO (IISNC)

**The Forum is a hybrid event. For queries, please write to: secretariat@unesco-iisnc.com**.

In person registration:
https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSeX65ozvslBoMSmaEdvqG2vXQH4Hi0QKjIheW4SkoOM4e7l6Q/viewform?usp=sf_link

**Venue**: 502, Conference room (5th floor), Library, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Click below to register and join Zoom Sessions:
https://us06web.zoom.us/meeting/register/tZYpduiuqTsjGt3N48q_Y9v5FtgTO9XBhg8Q

## Monday, 19 August 2024

08:30 – 09:00: Coffee/Tea/Registration

09:00 – 09:10: Music (Urtiin Duu and Morin Khuur) performance to open the Forum

09:10 – 09:30: Uradyn E. Bulag (University of Cambridge): Speech to open and explain the objective of the Forum

09:30 – 09:45: Greetings from:

- Ms Nomin Chinbat, Minister of Culture, Sports, Tourism and Youth of Mongolia
- H.E. Fiona Blyth, British Ambassador to Mongolia
- Mr. Bayar Sanj, Former Prime Minister of Mongolia

09:45 – 10:30: Keynote speech

**Nomadic Civilisation and Military Innovation**

Timothy May

(University of North Georgia)

For approximately 2,000 years (circa 500 BCE to 1,500 CE), the nomadic horse-archer was the dominant warrior in history. Then, in the modern era, which coincided with the advent of firearms, the military superiority of the Central Eurasian steppe nomads waned until the late 18th century, when sedentary states vanquished the last nomadic civilisations, thus bringing the nomadic populations of Eurasia under sedentary dominion. Since then, steppe warfare has generally been viewed as obsolete and its two millennia of success due to large numbers of horse-archers and their mobility as well as success with tactics such as the Parthian shot, feigned retreats, and enveloping tactics. Furthermore, the general perception has been that these tactics were time-tested and largely stagnant—unchanging over centuries. While history does support that the same tactics were used for centuries, outside observers and modern historians, however, have often missed or dismissed the larger significance of the military innovations that stemmed from nomadic societies. The innovations appeared not only in weapons and accoutrements, but also in tactics, strategies, as well as military formations and even as parts of state-building. Although the horse-archer may no longer have a place on the 21st century battlefield, the lessons of steppe warfare and steppe societies should still be considered for their application to modern warfare.

10:30 – 10:45: Coffee/Tea

Panel 1: Nomadic State Tradition and Its Relevance for Today
Chair: Uradyn E. Bulag

10:45 – 11:30: David Sneath (University of Cambridge)

**Aristocratic and Neoliberal Oligarchy Compared:**
**Examining the Property Regimes of Mongolia’s Pre- and Post-Socialist Ruling Elites**

Mongolia underwent two episodes of revolutionary change in the 20th century: firstly, the overthrow of a Buddhist aristocracy and the construction of a Soviet-style modernist nation-state, and then the collapse of state socialism and the introduction of a neoliberal market economy, and a parliamentary system. This paper compares and contrasts the ideological and material conditions of Borjigin elite rule during the pre-revolutionary period with those of Mongolia’s contemporary ‘oligarchic’ political order. In particular, it examines the property regimes of the pre- and post-Socialist political economies, and explores the nature of elite rights over resources, practices and persons.

11:30 – 12:15: Munkh-Erdene Lkhamsuren (National University of Mongolia)

**The Nomadic Origin of the State:**
**Extrahuman Transportation and Military Constitution**

Debunking the predominant theory of the origin of the state as a myth, resurrecting the conquest theory, and reinforcing it with the idea of extrahuman transportation, the paper argues for the nomadic origin of the state. The paper thus places nomadism at the origin of the state and civilisation and the Eurasian steppe at the centre of human history.

12:15 – 13:30: Lunch

Panel 2: Who is Afraid of Nomadic Civilisation?
Chair: David Sneath

13:30 – 14:15: Byambabaatar Ichinkhorloo and Turbat Tsagaan (National University of Mongolia)

**The UNESCO Promotion of Nomadic Civilisation: Perspectives from Mongolia**

This paper explores how Mongolia strategically utilised its UNESCO membership to revitalise Mongolian cultures and heritage, effectively challenging prevailing political narratives. Mongolia leveraged its UNESCO membership and participation in UNESCO conventions to promote its national cultures, alleviate domestic political pressures, and increase its international voice. Since joining in 1964, Mongolia achieved universal adult literacy in 1968, actively contributed to the publication of the six volumes of the History of Civilizations of Central Asia from 1976 to 2010 and took part in UNESCO's Silk Road Programme. This involvement led to the establishment of UNESCO representation offices and several affiliated research institutes and centres in Mongolia and other Central Asian countries between 1989 and 1998. In 2023, UNESCO adopted a resolution proposed by Mongolia to publish the UNESCO collection on the History of Nomadic Civilizations in six volumes. These initiatives and projects, intertwined with external and internal policy changes, have had a significant impact on Mongolian society, including academics and politicians.

14:15 – 15:00: Thomas White (King's College London)

**China's Camel Country: Rescaling Pastoralism as Heritage**

In recent decades, China has implemented a series of policies ostensibly designed to improve the country's degraded grasslands. Ethnic minority pastoralists, blamed for causing desertification through overgrazing, have been resettled away from the grasslands, or subjected to restrictions on their animal-based livelihoods. In this paper, I show how ethnic Mongols in Alasha—western Inner Mongolia—have contested this stigmatisation of pastoralism by adopting the discourse of local heritage protection to defend camel husbandry. In doing so, however, they have also had to rescale pastoralism away from its association with the Mongol nationality, in line with the economic and nation-building priorities of the Chinese state. I thus argue that the reimagining of pastoralism as heritage is shaped by particular political contexts.

15:00 – 15:45: Carole Ferret (Centre National de la Recherche Scientifique / French National Centre for Scientific Research)

**The Ambiguities of the Kazakhs' Nomadic Heritage**

After the independence of Kazakhstan in 1991, the Kazakhs emphasised their nomadic heritage as the basis of their national identity. Nonetheless, they remain influenced by negative representations of nomadism, and struggle to reconcile pastoralism with modernity.

In the 19th and 20th centuries, debates about sedentarisation showed all the ambivalence of the Russian and Kazakh positions on the topic. In the 1930s, forced sedentarisation was a side effect of collectivisation, which led to a tragic famine that killed a third of the Kazakh population. Following independence, the patrimonialisation of nomadism focused on some ancillary emblems, such as the yurt or the horse. For instance, Kyrgyzstan and Kazakhstan compete to appropriate the Central Asian equestrian game of goat-pulling, misinterpreted as a 'nomadic game'. This patrimonialisation of nomadism neglects its essential feature, residential mobility, and, in ignoring actual nomadic practices, it definitively relegates nomadism to the past. However, ethnographic field studies, such as the one I carried out in southeastern Kazakhstan, show that mobile pastoralism is still practised today.

15:45 – 18:00: Special Exhibition: Chinggis Khaan: How the Mongols Changed the World
Chinggis Khaan National Museum

18:30 – 20:00: Reception (Novotel Hotel, first floor)

## Tuesday, 20 August 2024

08:30 – 09:00: Coffee/Tea

**Panel 3: Nomad Games and Nation Branding**
Chair: Timothy May

09:00 – 09:35: Tyntchtykbek Tchoroev (Chorotegin) (Kyrgyz National University named after Jusup Balasagyn):

### Kyrgyzstan as the Centre of the Nomad World: Tourism and the World Nomad Games

The Kyrgyz are amongst those Central and Inner Asian peoples who developed nomadic traditions of sports and other games from ancient and medieval times and preserved them until the modern era. The Turkic runic-style inscriptions, the ethnographic data in the Diwanu Lugati t-Turk by Mahmud Kashghari Barskani, the rich information in the Kyrgyz epic of Manas, and other historical and ethnographic materials show that the nomadic sport games were inseparable parts of Kyrgyz community life.

The special episode of the epic of Manas entitled 'Feast to Commemorate Koekoetoey Khan' is the epic story of the medieval Olympic-style nomadic games where the Kyrgyz invited all the historical neighbours, even foes in Central, Inner and East Asia. It is interesting to mention that a scandal during the astragalus game of Ordo in 1854 was a pretext for the war between the Kyrgyz tribes of Bughu and Sarybagysh in the 1850s. However, these games were often part of diplomatic efforts to reach peace amongst tribes and nations in the past. They were a cultural aspect of qurultays, feasts, celebrations, and other important social gatherings.

Kyrgyzstan has preserved its national sports games even during the Communist era (1918–1991). The national games were part of the seasonal celebrations of the Kolkhoz and Sovkhoz herders and other workers. During the second decade of the 21st century, Kyrgyzstan, as a modern republic with the nomadic traditions, implemented a new practice of organising the Olympic style sports and ethnographic events called World Nomad Games. The Kyrgyz Republic held the Games three times (2014, 2016, 2018) and managed to make it a sustainable international sports event, before passing the organisation of the games to Turkey (Iznik, 29 September – 2 October 2022) and Kazakhstan (Astana, 8–14 September 2024). Hopefully, the Kyrgyz Republic will host the Sixth World Nomad Games.

The sports events helped Kyrgyz tourism reshape itself by organising a seasonal tourist industry centred around nomadic themes. Modern yurts with electricity and other amenities can now be found in almost all the Alpine-style high mountainous valleys of Kyrgyzstan, welcoming international and domestic tourists during the summer months. With a new burgeoning winter tourism industry supported by a myth that Santa Claus originated in the Kyrgyzstan mountains,

now the Central Asian republic is now thriving as one of the modern tourism centres of the Nomad World.

09:35 – 10:10: Azamat Maksüdünov (Kyrgyz-Turkish Manas University, Bishkek)

**Economic and Socio-Cultural Aspects of World Nomad Games as a Large-Scale Event**

Various types of large-scale events, such as the Olympic Games, World Championships, festivals have a dramatic character, mass popular appeal, and international significance. Events of this nature can have substantial positive or negative economic, cultural, and social effects on the hosting region. The World Nomad Games (WNG), as a large-scale event, have also created various impacts in host countries. In this presentation, I will focus on some economic and socio-cultural impacts of hosting the WNG in Kyrgyzstan. More specifically, the role of the WNG in promoting the country as a tourism destination and nation branding, as well as its role in promoting the preservation and development of nomadic culture, will be discussed in detail. This unique large-scale event was organised three times in Kyrgyzstan, with the first event taking place in 2014. As the country that hosted the first three WNGs, it is crucial to share Kyrgyzstan's experiences. This emerging event, which offers an alternative platform for ethnic sports, has had a positive economic and socio-cultural impact on Kyrgyzstan. It revitalises nomadic cultural values and promotes them around the world.

10:10 – 10:45: Bum-Ochir Dulam (Member of Parliament of Mongolia); Munkh-Uchral Enkhtur (National University of Mongolia)

**Nation Branding and the Historical Construction of the Mongol National Character**

This paper examines the recent emergence of the concept of ündesnii ünet züil (national value) in Mongolia, focusing on the efforts of the Mongolian National Branding Council (MNBC) in promoting the historical construction of a national character and studying personality traits. The first part of the paper provides a brief introduction to the establishment of the MNBC in 2017, under the leadership of the then Prime Minister, which recently ceased operations. The second part discusses the emergence and expansion of the concept of ündesnii ünet züil (national value) or ündesnii negdmel ünet züil (national uniting value). The third part presents key outcomes of the MNBC research project titled Mongol khünii erkem chanar, zan surtakhuuny survaljiin sudalgaa (Primary source studies of the Mongols’ valued characters and personality traits) conducted by the authors of this paper. The paper concludes by arguing that the study of national character, which emerged in the fields of anthropology and psychology in the mid-20th century

and during WW2 in America, is now becoming a research topic in contemporary Mongolia within the context of nation branding rather than war.

10:45 – 11:00: Coffee/Tea

**Panel 4: Nomadic Ways to Mongolia's Development?**
Chair: Byambabaatar Ichinkhorloo

11:00 – 11:40: Temuujin Jadambaa (Citi University, Mongolia), Dolgorsuren Jamiyan (Citi University, Mongolia), Zoljargal Enkh-Amgalan (University of Cambridge)

## How Clean is the Mongolian Steppe? From Nomadic to Modern Ways of Utilising Various Types of Waste and Modern Technological Solutions

The need to survive in a vast area with four alternating seasons and a thin layer of soil has fostered a culture that respects nature and practices an ecologically friendly lifestyle. The domesticating animals, fundamental to Mongolia's development, has cultivated a culture of knowledge, love, and protection of the natural world, along with religious taboos and a simple way of life. As urbanisation and industrialisation has expanded, more waste has been generated, leading to the creation of landfills. For instance, 210,000 families live in the Ger neighbourhoods of Ulaanbaatar, consuming more than 800,000 tonnes of coal as fuel. Ulaanbaatar's power plants burn about 5 to 6 million tonnes of coal annually, releasing over 500,000-600,000 tonnes of coal combustion by-products.

Throughout this collective paper, we examine Mongolia's waste sector and management from a variety of perspectives, including traditional knowledge of respecting nature and an environmentally friendly culture. Additionally, we address the current conditions of managing central landfills and explore technological solutions for producing energy from waste ash.

We will start by exploring the cultural and historical practices of Mongols in maintaining cleanliness in their steppe environments and homes. Next, we will present ethnographic observations that shed light on the material, environmental, and human dimensions of the Ulaanchuluut landfill. We will then address the challenges associated with coal-fired thermal power plants, which produce significant amounts of waste ash that pose environmental and health risks. We will argue that exploring methods to convert this ash into value-added products in an eco-friendly manner is essential and aligns with the country's sustainable development goals. Finally, we will evaluate the potential use of fly ash and pond ash in producing concrete, geopolymers, and glass ceramics.

11:40 – 12:20: Elizabeth Fox (University of Cambridge) and Enkhbat Sainbayar (University of Cambridge):

### Introducing the Mongolian Meat Standard: Nomadic Solutions to World Meat Production Problems, or, What can Mongolia Teach the World about Meat Production?

As global demand for meat increases, so, too, do anxieties about the way animals are raised and exploited in industrialised meat production systems. Questions of ethics, sustainability, health, and climate impact make meat a highly valued but ambiguous foodstuff. This paper asks what Mongolia might offer a world plagued with meat production issues and ever-homogenising tastes. Instead of looking to meet foreign standards—as meat businesses in Mongolia are generally encouraged to—our proposal flips the script to imagine a world where Mongolia leads the way in setting the standard for ethical and sustainable meat production. In this reimagining, the Mongolian Meat Standard becomes the certification to which domestic and even international meat producers aspire. Drawing on Mongolia's wealth of pastoral animal husbandry expertise, our presentation outlines what a Mongolian Meat Standard could be.

12:20 – 13:00: Eric Thrift (University of Winnipeg); Munkhtamir Damdinsuren (IISNC); Mijid Sainbuyan (IISNC)

### Defining 'Nomad-Friendly' Cashmere: Cultural Sustainability in the Cashmere Commodity Chain

Whereas the marketing of cashmere apparel has traditionally highlighted luxury and indulgence, global fashion labels have increasingly adopted sustainability as an element of their branding. In partnership with international charities and development organisations, or through their own corporate social responsibility initiatives, fashion designers and retailers have attempted to certify and market their apparel as 'sustainable cashmere'. Cashmere-producing herders are themselves also branded through this process, marked by their willingness to participate in self-regulation and self-improvement regimes. Through ethnographic research investigating the ways that Mongolian herders perceive and navigate sustainable branding and certification initiatives, we find that the concept of 'sustainable cashmere' brings a narrow, technical scope to the political economy of pastoralism. Herders' own political concerns, often articulated with reference to the safeguarding of nomadic pastoral cultural heritage and identity, may better be captured in international branding through the concept of 'cultural sustainability'.

**13:00 – 14:00: Lunch**

14:00 – 15:30: **Modern Challenges of Nomadic Representation in Contemporary Arts of Mongolia: A Dialogue**

Chair: Bum-Ochir Dulam

Uranchimeg Tsultem (Indiana University–Bloomington)
Tsetsentsolmon Baatarnaran (National University of Mongolia)
Enkhbold T., artist
Munkhtsetseg L., artist
Erdenebat B., music producer

Conventional portrayals and artistic representations of nomadism have been inspired by the legacy of the Mongol Empire and nomadic pastoralism. The rapid increase in urbanisation and the impact of contemporary Western art in Mongolia in recent years have led to more global cosmopolitan perspectives, resulting in a diverse and dynamic landscape in contemporary Mongolian arts and music. Despite the dominant state-supported ideology of nomadism as the roots of Mongolian culture, artists now prioritise expressing their individual uniqueness rather than conforming to existing ideologies, and institutional patterns and social norms.

In this session, we will explore a range of artistic representations in contemporary visual art and music by showcasing the works of well-established and emerging young artists, who include Enkhbold T. and Munkhtsetseg L., as well as a music producer Erdenebat B. Through academic and artistic dialogue, we aim to question the various interpretations and representations of nomadism in these creative practices.

15:30 – 16:45

**Roundtable Discussion: Nomadism and Its Geopolitical Significance**
Chair: Uradyn E. Bulag

Timothy May, David Sneath, Munkh-Erdene Lkhamsuren, Bum-Ochir Dulam, Tyntchtykbek Tchoroev, Byambabaatar Ichinkhorloo, Carole Ferret, Eric Thrift, Thomas White, Uranchimeg Tsultem and Elizabeth Fox

17:15 – 18:15: **Special Exhibition: Beyond Nomadism in Mongolia**
Curated by Uranchimeg Tsultem, Mongolian National Art Gallery; 19-21 August 2024

**18:30 - 20:00: Dinner for speakers** (Asiana Central Restaurant, Central Tower)

КЕМБРИЖ МОНГОЛ ФОРУМ II

# ДЭЛХИЙН АСУУДАЛ, НҮҮДЭЛЧДИЙН ШИЙДЭЛ

2024 оны Наймдугаар сарын 19-20

Улаанбаатар хот

Монгол улс өнгөрсөн зуунд үндэсний ижилслийн хувьд ихээхэн өөрчлөлтийг даван туулсан. Нүүдэлчин амьдралын хэв маяг, феодалын болон социализмын үеийн түүх нь Монголчуудыг бурангуй, хоцрогдсон үндэстэн мэтээр төлөөлж байсан бол өдгөө Чингис хааны болон нүүдлийн соёл иргэншлийн өвд суурилсан түүх, соёлоороо бахархах үндэсний ижилслийг бий болгож байна. Энэхүү өөрчлөлт нь ялангуяа Ковид-19 цар тахлын дараах үеийн хоёр том бүтээн байгуулалтаар илэрч байна. Нэгдүгээрт, үндэсний соёлын тэргүүлэх байгууллага болох Чингис хаан үндэсний музейг байгуулсан, хоёрдугаарт, Монгол үндэстэн дэлхийн нүүдэлчдийн болон нүүдлийн соёл иргэншлийн төв болохоо харуулахыг зорьсон Нүүдэлчин дэлхийн соёлын наадмыг зохион байгуулж эхэлсэн болно.

Нүүдэлчин ахуй, өв соёлоо онцлон анхаарч байгаа нь  дан ганц Монгол Улс биш юм. Тиймээс өдгөө нүүдэлчдийн өв соёлоо ямар нэгэн хэмжээгээр хадгалж, хамгаалж буй Хятад, Орос, Төв Азийн орнууд зэрэг бусад улс үндэстнүүдтэй харьцуулахад Монгол улс хаана байна вэ? гэсэн асуулт гарч байна. Тиймээс энэхүү форум нь Чингис хаан ба нүүдлийн соёл иргэншил нь Монголын төдийгүй дайн тулаан, уур амьсгалын өөрчлөлт зэрэг өнөөгийн дэлхийн нийтэд тулгамдаж буй асуудлуудад шийдэл олоход чухал ач холбогдолтой гэж үнэлж, цаашлаад Монголын шинэ алсын хараны үндэс суурийг хэлэлцэх талбар болно.

**Зохион байгуулагч:**

Кембрижийн их сургуулийн Монгол ба Дотоод Ази судлалын төв (MIASU).
Монгол Улсын Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яам
ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
Чингис Хааны өв соёлын хүрээлэн
Монгол Улсын их сургуулийн Монгол судлалын хүрээлэн
Сити их сургууль
Монголын Уран Зургийн Галерей

**Зохион байгуулах хороо:**

- Профессор Урад Э.Булаг /Кембрижийн их сургуулийн профессор/
- Профессор Д. Бум-Очир /Монгол Улсын Их Хурлын гишүүн/
- И. Бямбабаатар / Монгол Улсын Их Сургуулийн Монгол судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор /
- Ч.Мөнхтуул / ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал, доктор /
- Н.Саруул /Чингис Хааны өв соёлын хүрээлэнгийн захирал, доктор /

**Зохицуулагч:** ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн (НСИСОУХ)

Форум нь танхимаар болон цахимаар зохион байгуулагдана. Форумтай холбоотой асуудлаар secretariat@unesco-iisnc.com хаягаар холбогдоно уу.

Танхимаар оролцох бүртгэл: https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSeX65ozvslBoMSmaEdvqG2vXQH4Hi0QKjIheW4SkoOM4e7l6Q/viewform?usp=sf_link
**Хаяг**: 502 тоот хурлын танхим (5 давхар), Монгол Улсын Их Сургуулийн Номын сан, Улаанбаатар, Монгол

Цахимаар оролцох бүртгэл: https://us06web.zoom.us/meeting/register/tZYpduiuqTsjGt3N48q_Y9v5FtgTO9XBhg8Q

**Эхний өдөр: 8 сарын 19-ний Даваа гараг**

**08:30 - 09:00: Бүртгэл**

09:00 – 09:10: Форумын нээлт - уртын дуу, морин хуур

09:10 – 09:30: Урадын Э. Булаг (Кембрижийн их сургууль): Форумын тухай танилцуулга

09: 30 - 09:45: Нээлтийн мэндчилгээ

- Монгол Улсын Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын Сайд Ч. Номин
- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Фиона Блайт
- Монгол Улсын Ерөнхий сайд асан С. Баяр

## Үндсэн илтгэл

09:45 - 10:30: Тимоти Мэй (Норт Жиоржиагийн Их сургууль)

**Нүүдлийн соёл иргэншил ба цэргийн инноваци**

Ойролцоогоор 2000 жилийн турш (МЭӨ 500-аас МЭ 1500 он хүртэл) нүүдэлчин морьт харваачид түүхэн дэх зонхилох дайчид байсаар ирсэн. Гэвч галт зэвсэг бий болж хэрэглэгдэх болсон орчин цаг үед Төв Евразийн тал хээрийн нүүдэлчдийн цэргийн давуу байдал XVIII зууны сүүл үе хүртэл суларч улмаар суурин соёл иргэншил зонхилох болсон байна. Үүнээс улбаалан тал нутгийн дайн байлдаан төдийгүй тэдний хоёр мянган жилийн ололт амжилт, түүнд нөлөөлсөн олон тооны морин харваачид, тэдний шилжилт хөдөлгөөн, Парфийн харваа (Parthian shot), ухран давшлах, бүслэх гэх мэт дайны тактикууд улиран үгүй болсон хэмээн үздэг. Түүхэн баримтаас эдгээр тулааны арга барилууд олон зууны туршид хувирч өөрчлөгдөлгүй шалгарч үлдсэн гэдэг ерөнхий ойлголтыг авч болох хэдий ч орчин үеийн түүхчид болон судлаачид ихэвчлэн нүүдэлчдийн нийгмээс үүдэлтэй зэвсэгт хүчний ололт амжилтын ач холбогдлыг орхигдуулах мөн үгүйсгэх явдал байдаг. Эдгээр ололт амжилт зөвхөн зэр зэвсэг, хуяг дуулгаар зогсохгүй тулааны тактик, стратеги, цэргийн бүрэлдэхүүн цаашлаад төрийн байгуулалтын тодорхой нэгжүүдэд илэрдэг. Хэдийгээр XXI зууны тулааны талбарт морин харваачдын ач холбогдол байхгүй ч тал нутгийн дайтах урлагийн мэдлэг, мэдээллийг орчин үеийн зэвсэгт хүчний хэрэглээнд авч үзэх хэрэгтэй байна.

**10:30 - 10:45: Цайны завсарлага**

## Панел 1: Нүүдэлчдийн төрт ёсны уламжлал ба өнөөгийн хамаарал

Чиглүүлэгч: Урадын Э. Булаг

10:45 - 11:30: Дэвид Снит (Кембрижийн их сургууль):

**Монголын социализмын өмнөх болон дараах үеийн эрх баригч элитүүдийн өмчийн дэглэмийг судлах нь: Аристократ ба неолиберал олигархуудын харьцуулсан жишээн дээр**

XX зуунд Монгол Улс хувьсгалт өөрчлөлтийн хоёр үе шатыг туулсан байдаг. Нэгдүгээрт, буддын шашны язгууртнуудыг түлхэн унагаж Зөвлөлт маягийн модернист үндэстэн улсыг байгуулж, дараагаар нь социалист төр нуран неолиберал зах зээлийн эдийн засаг болон парламентын засаглалд шилжжээ. Энэхүү илтгэлд хувьсгалаас өмнөх үеийн Боржигин овогтны элит ноёрхлын үе дэх үзэл суртлын болон эд хөрөнгийн байдлыг Монголын өнөөгийн “олигархи” улс төрийн дэглэмтэй харьцуулсан юм. Ялангуяа социализмын өмнөх болон дараах үеийн улс төрийн эдийн засаг дахь өмчийн дэглэмийг судалж, нөөц баялаг, үйл ажиллагаа, хүмүүстэй холбогдох элитүүдийн эрхийн мөн чанарыг судлав.

11:30 - 12:15: Л. Мөнх-Эрдэнэ (Монгол Улсын Их Сургууль)

**Төрийн нүүдэлчин үүсэл: Хүнээс ангид тээврийн хэрэгсэл хийгээд цэргийн байгуулалт**

Эл өгүүлэл төрийн үүсэл гарлын тухай зонхилох онолыг үлгэр домог хэмээн үгүйсгэн, төрийн үүслийн тухай байлдан дагуулалтын онолыг сэргээн, түүнийг хүнээс ангид тээврийн хэрэгсэл хэмээх ойлголтоор сайжруулах замаар нүүдэлчид төр улсыг үүсгэн байгуулсан гэсэн санааг дэвшүүлж байгаа болно. Эл учир, тус өгүүлэл төр улс, соёл иргэншлийн эхэнд нүүдлийн байгууллыг, хүн төрөлхтний түүхийн төвд Евроазийн тал нутгийг тавьж байгаа болно.

**12:15 - 13:30: Үдийн хоол**

**Panel 2: Нүүдлийн соёл иргэншлээс хэн айдаг вэ?**

Чиглүүлэгч: Дэвид Снийт

13:30 - 14:15: И. Бямбабаатар, Ц.Төрбат (Монгол Улсын Их Сургууль)

**ЮНЕСКО-ийн Нүүдлийн соёл иргэншлийг дэмжих хандлага: Монголын хэтийн төлөв**

Энэхүү илтгэл нь Монгол Улс уламжлалт соёл, соёлын өвөө хамгаалах, сэргээхийн тулд ЮНЕСКО-ийн гишүүнчлэлээ хэрхэн амжилттай ашиглаж, тогтсон улс төрийн хэлэлцүүлэг, өгүүлэмжийг хэрхэн үр дүнтэйгээр даван туулсан талаар өгүүлэх болно. Монгол Улс үндэсний соёлоо сурталчлах, дотоодын улс төрийн дарамт шахалтыг намжаах, олон улсын хэмжээнд дуу хоолойгоо нэмэгдүүлэхийн тулд ЮНЕСКО-ийн гишүүнээр элсэж, ЮНЕСКО-ийн конвенциудад нэгдсэн орох болсон. Монгол Улс 1964 онд ЮНЕСКО-ийн гишүүн улс болсноос хойш 1968 онд насанд хүрэгчид бүх нийтээрээ бичиг үсгийн боловсрол эзэмшиж, 1976-2010 онуудад “Төв Азийн соёл иргэншлүүдийн түүх” зургаан ботийг хэвлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулж, ЮНЕСКО-ийн “Торгоны зам” хөтөлбөрт хамрагдсан. Эдгээр идэвхтэй оролцоо нь мөн 1989 болон 1998 онуудад Монгол Улс болон Төв Азийн орнуудад ЮНЕСКО-ийн төлөөлөгчийн газар, хэд хэдэн харьяа судалгааны хүрээлэн, төвүүдийг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. 2023 онд “ЮНЕСКО-гийн Нүүдлийн соёл иргэншлийн түүх” зургаан боть цуврал ном хэвлүүлэхээр Монгол Улсаас санал болгосон тогтоолыг ЮНЕСКО баталсан. Гадаад, дотоод бодлогын өөрчлөлттэй уялдсан эдгээр санаачилга, төслүүд Монголын нийгэм, тэр дундаа эрдэмтэн судлаачид, улстөрчдөд ихээхэн нөлөөлсөн.

14:15 - 15:00: Томас Вайт (Лондоны эзэн хааны коллеж)

**Хятадын Тэмээн нутаг: Бэлчээрийн мал аж ахуйг соёлын өв болгох нь**

БНХАУ сүүлийн арваад жил талхлагдсан бэлчээр нутгийг нөхөн сэргээх талаар бодлого хэрэгжүүлж байна. Үүнд, үндэсний цөөнхийн малчдыг бэлчээр талхлалтад буруутгаж, бэлчээрийн бүсээс нүүлгэн шилжүүлэх, малын тоо толгойг хянах, хязгаарлах бодлого хэрэгжиж байгаа билээ. Энэхүү өгүүлэлд Өвөр Монголын баруун бүсэд орших Алшаагийн монголчууд уг бодлогыг хэрхэн эсэргүүцэж, түүндээ тэмээний аж ахуйг хамгаалахын тулд орон нутгийн өв соёлыг хамгаалах тухай яриа өрнүүлэх болсоныг тайлбарлах болно. Тиймээс Хятад улсын эдийн засаг, үндэстэн байгуулалтын тэргүүлэх чиглэлийн дагуу бэлчээрийн мал аж ахуйг монгол үндэстнээс салгахаас өөр арга хэмжээ авах шаардлагатай болсон. Иймд бэлчээрийн мал аж ахуйг өв болгон дахин төсөөлөх нь улс төрийн тодорхой нөхцөл байдлаас шалтгаалдаг гэж үзэж байна.

15:00 - 15:45: Кэрол Феррет (Францын үндэсний Судалгааны Төв)

**Казахуудын нүүдэлчдийн соёл, өвийн тодорхой бус байдал**

Казахстан Улс нь 1991 онд тусгаар тогтнолоо сэргээж, нүүдэлчдийн өв соёлоо үндэсний бахархал, өвөрмөц байдлын үндэс болгосон юм. Гэсэн хэдий ч нүүдэлчдийн талаарх сөрөг хэвшмэл ойлголтууд хэвээр үлдэж, бэлчээрийн мал аж ахуй болоод орчин үежилтийг хослуулахад бэрхшээл тулгарсаар байна. Орос болон Казахстан нь XIX болоод XX зууны үед дээрх асуудал дээр хоёрдмол байр суурьтай байсныг эргэн санах хэрэгтэй. 1930-аад онд Казахуудыг албадан суурьшуулах, нэгдэлжүүлэх бодлогын үр дүнд нийт хүн амын гуравны нэг нь өлсгөлөнд нэрвэгдсэн үр дагавар гарч байсан. Тусгаар тогтносны дараа гэр, морь гэх мэт зарим туслах бэлгэдлүүд дээр төвлөрсөн нүүдлийн соёлыг чухалчлах болсон. Тухайлбал, Киргиз, Казахстан улсууд "нүүдэлчдийн тоглоом" хэмээн буруу тайлбарласан Төв Азийн морин дээрээс ямаа булаалдах тоглоомыг өөрийн болгохоор өрсөлддөг. Гэвч энэхүү нүүдлийн соёлын чухалчлал нь номадизмын үндсэн шинж чанар нүүдэл, суудал, нүүдэлчдийн бодит зан үйлийг үл тоомсорлож, номадизмыг түүхийн өнгөрсөн үе рүү шилжүүлдэг. Гэсэн хэдий ч зүүн өмнөд Казахстанд хийсэн этнографийн хээрийн судалгаан дээр үндэслэн үзвэл нүүдлийн мал аж ахуй өнөөдрийг хүртэл амь бөхтэй оршин тогтносоор байгаа юм.

15:45 - 18:00 Илтгэгчид Чингис хааны үндэсний музейд зочилж, "Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь" үзэсгэлэн үзнэ.

18:30 - 20:00: Хүлээн авалт (Новотел зочид буудлын нэгдүгээр давхар)

## Хоёр дахь өдөр: 2024 оны 8 сарын 20-ны Мягмар гараг

**08:30 - 09:00: Цайны завсарлага**

**Панел 3: Нүүдэлчдийн наадам: Өрсөлдөөн ба хамтын ажиллагаа**
Чиглүүлэгч: Тимоти Мэй

09:00 - 09:35: Тынчтыкбек Чороев (Киргизийн Үндэсний Их сургууль)

**Киргиз Улс нүүдэлчдийн ертөнцийн төв болох нь: Аялал жуулчлал ба "Дэлхийн нүүдэлчдийн наадам"**

Киргизүүд нь бүхий л түүхэн цаг үеэс өнөөдрийг хүртэл нүүдэлчдийн спорт, тоглоом наадгай, уламжлалыг тээж, хадгалсаар ирсэн Төв ба Дотоод Азийн ард түмний нэг юм. Түрэгийн руни бичээс болох Махмуд Кашгари Барсканигийн "*Diwanu Lugati t-Turk"*, Киргизийн "Манас" туульсаас нүүдэлчдийн спорт, тоглоом наадгайтай холбоотой арвин их түүх, угсаатны зүйн баримтыг харж болдог. Манас туулийн "Көкөтөй хааны дурсгалд зориулсан наадам" гэх хэсэгт Киргизүүд нь төв, дотоод, зүүн Азийн өстөн дайснаа ч нүүдэлчдийн наадамд урин оролцуулж, нүүдэлчдийн "олимп"-ыг зохион байгуулдаг байсан тухайг гардаг. 1854 оны "Ордо" наадмын үед болсон наадамчдын зөрчилдөөн, маргалдаан нь 1850-иад оны үед өрнөсөн Киргизийн Бугу, Сарыбагыш овог хоорондын дайны шалтгаан болсон сонирхолтой түүх ч бий. Гэсэн хэдий ч нүүдэлчдийн наадам нь овог аймаг, үндэстэн хоорондын энх тайвныг бататгах дипломат үйл хэргийн нэг хэсэгт тооцогддог байсныг дурдах хэрэгтэй. Уг наадам нь их хуралдай, найр наадам, баяр ёслол болоод бусад нийгмийн үйл хэргийн чухал хэргийн нэг болж байлаа.

Киргизүүд коммунист (1918–1991) дэглэмийн үед ч үндэсний спортоо хадгалсаар ирсэн. Улсын наадам нь Колхоз, Совхоз малчид болоод бусад ажилчин ангийн улирлын чанартай баяр наадмын нэг хэсэг болж байв. XXI зууны хоёр дугаар арван жилд Киргиз Улс нь тусгаар тогтносон, бүгд найрамдах улсын хувьд "Дэлхийн нүүдэлчдийн наадам" хэмээх олимпын хэв маягтай спорт, угсаатан зүйн арга хэмжээг зохион байгуулах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Бүгд Найрамдах Киргиз улс тус наадмыг гурван удаа (2014, 2016, 2018) зохион байгуулж, Турк (Изник, 2022 оны 9-р сарын 29-өөс 10-р сарын 2) болон Казахстанд (Астана, 2024 оны 9-р сарын 8-14) шилжүүлсэн. Бүгд Найрамдах Киргиз Улс Дэлхийн нүүдэлчдийн VI наадмыг зохион байгуулна гэж найдаж байна. Спортын арга хэмжээнүүд нь Киргизийн аялал жуулчлалыг нүүдэлчдийн сэдэвт улирлын чанартай аялал жуулчлалын салбар болгон өөрчлөхөд тусалсан. Киргизийн бараг бүх Альпийн хэв маягийн өндөр уулархаг хөндийд цахилгаан эрчим хүч болон бусад тохь тух бүхий орчин үеийн гэр хотхонууд байгуулж, зуны улиралд гадаад, дотоодын жуулчдыг хүлээн авах боломжтой болсон. Цаашлаад өвлийн аялал жуулчлалын шинэ салбарыг Киргизийн уулсаас гаралтай гэсэн үлгэр домогт тулгуурлан, Төв Азийн Бүгд Найрамдах

Улс Нүүдэлчдийн ертөнцийн орчин үеийн аялал жуулчлалын төвүүдийн нэг болон хөгжиж байна.

09:35 - 10:10: Азамат Максудунов (Киргиз-Туркийн Манас их сургууль)

**“Дэлхийн нүүдэлчдийн наадам” нь эдийн засаг, нийгэм, соёлын асуудлыг хамарсан том арга хэмжээ болох нь**

Олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн гэх мэт олон төрлийн үйл ажиллагааг хамруулсан томоохон арга хэмжээ нь олон нийтийн анхаарлыг татдаг, олон улсад ач холбогдолтой байдаг. Ийм шинж чанартай үйл явдлууд нь тухайн бүс нутагт эдийн засаг, соёл, нийгэмд эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлдэг. “Дэлхийн нүүдэлчдийн наадам” нь томоохон хэмжээний арга хэмжээний хувьд зохион байгуулагч орнуудад янз бүрийн нөлөө үзүүлсэн. Энэхүү танилцуулгад би “Дэлхийн нүүдэлчдийн наадам”-ыг Киргиз улсад зохион байгуулах нь эдийн засаг, нийгэм соёлын зарим нөлөөллийн талаар ярих болно. Тодруулбал, тус улсыг аялал жуулчлалын бүс болгон сурталчлах, үндэсний брэнд болгоход “Дэлхийн нүүдэлчдийн наадам”-ын гүйцэтгэх үүрэг, нүүдэлчдийн соёлыг хадгалан хамгаалах, хөгжүүлэхэд ямар үүрэг гүйцэтгэж байгаа талаар дэлгэрэнгүй өгүүлнэ. Киргиз Улс нь уг арга хэмжээг нийт 3 удаа зохион байгуулсан бөгөөд 2014 онд анх удаа зохион байгуулж байжээ. Киргиз Улс нь уг наадмыг санаачлагчийн хувьд Киргизийн туршлагаас хуваалцах нь чухал юм. Угсаатны спорт, тоглоом наадгайг шинэ түвшинд гарган ирж буй уг арга хэмжээ нь Киргиз Улсын эдийн засаг, нийгэм, соёлд эерэг нөлөө үзүүлсэн. Цаашлаад нүүдэлчдийн соёлын үнэт зүйлсийг сэргээж, дэлхий дахинд сурталчлахад чухал нөлөө үзүүлсэн юм.

10:10 - 10:45: Д. Бум-Очир **(**Монгол Улсын Их Хурлын гишүүн**),** Э. Мөнх-Учрал (Монгол Улсын Их Сургууль)

**Үндэсний брэндинг ба Монгол үндэстний зан чанарын түүхэн замнал**

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад үндэсний үнэт зүйл гэх ойлголт сүүлийн үед бий болсонтой холбоотой асуудлыг судалж, Монголын Үндэсний Брэндийн Зөвлөл (МҮБЗ)-ийн Монгол үндэстний болон хувь хүний зан чанарын түүхэн ач холбогдлыг судлахад чиглэсэн хүчин чармайлтыг онцлон авч үзсэн болно. Өгүүллийн эхний хэсэгт үйл ажиллагаа нь зогсоод удаагүй байгаа 2017 онд тухайн үеийн Ерөнхий сайдын удирдлага дор байгуулагдсан МҮБЗ-ийн тухай товч танилцуулгыг хүргэх бол хоёрдугаар хэсэгт үндэсний үнэт зүйл мөн үндэсний нэгдмэл үнэт зүйл гэсэн ойлголтын үүсэл хөгжлийн талаар авч үзнэ. Гуравдугаар хэсэгт тус өгүүллийн зохиогчдын хийсэн “Монгол хүний эрхэм чанар, зан суртахууны сурвалжийн судалгаа” хэмээх МҮБЗ-ийн судалгааны төслийн гол үр дүнг танилцуулна. Төгсгөлд нь XX зууны дунд үе болон дэлхийн II дайны үед Америк, Японы антропологи, сэтгэл судлалын салбарт дайнтай холбоотойгоор

дэлгэрсэн Үндэстний зан чанарын судалгаа өнөө үед Монголд үндэсний брэндингийг бүтээх бодлогын хүрээнд хэрхэн хөгжиж буй талаар өгүүлэх болно.

**10:45 - 11:00: Цайны завсарлага**

**Панел 4: Монгол улсын хөгжилд нүүдлийн соёлын нөлөө**
Чиглүүлэгч: Д. Бум-Очир

11:00 - 11:40: Ж. Тэмүүжин (Сити их сургууль), Ж. Долгорсүрэн (Сити их сургууль), Э. Золжаргал (Кембрижийн их сургууль)

**Тал нутаг хэр цэвэрхэн бэ? Уламжлалт соёлоос эхлээд хог хаягдлыг ашиглах өнөөгийн нөхцөл байдал болоод орчин үеийн технологийн шийдэл**

Эрс тэс уур амьсгалтай дөрвөн улирал ээлжилдэг, хөрсний нимгэн давхаргатай өргөн уудам нутагт бэлчээрийн мал аж ахуй эрхэлж амьд үлдэх, тэсэж гарах шаардлага нь байгалийн жам ёсыг хүндэтгэж, байгаль экологид ээлтэй аж төрөх нийгэм, соёлыг бүтээн уламжилж ирсэн нь өнөөгийн хөгжлийн суурь үндэс болсон. Таван хошуу мал гаршуулах үйл явц, байгаль дэлхийгээ судлах, хайрлан хамгаалах, сүсэг бишрэл, хорио цээр, энгийн хялбархан аж төрөх ёс, цэвэр цэмцгэр, байгальд ээлтэй соёл иргэншлийг бүтээсэн. Харин хотжилт, үйлдвэржилт өргөжихийн хэрээр хог хаягдал ихсэж, хогийн цэгүүд бий болов. Тухайлбал, Улаанбаатар хотын гэр хороололд 210 мянган өрх амьдарч, 800 гаруй мянган тонн нүүрсийг түлш болгон ашиглаж байна. Улаанбаатар хотын цахилгаан станцууд жилд 5-6 сая тонн орчим нүүрс түлдэг бөгөөд үүнээс 500-600 гаруй мянган тонн нүүрсний шаталтын дайвар бүтээгдэхүүн ялгардаг. Энэхүү хамтарсан илтгэлээр бид Монголын хог хаягдлын салбар, менежментийг олон талаас нь авч хэлэлцэх болно. Жишээлбэл, байгальд ээлтэй соёлыг дээдлэх уламжлалт мэдлэг, төвлөрсөн хогийн цэгийг зохион байгуулах өнөөгийн нөхцөл байдал, мөн хаягдал үнснээс эрчим хүч үйлдвэрлэх технологийн шийдлүүд зэрэг өргөн хүрээний сэдвүүд багтана. Бид эхлээд монголчуудын тал нутаг, гэр орноо цэвэр ариун байлгах соёл, түүхийн талаар хэлэлцэх болно. Мөн илтгэлийн хоёр дахь хэсэгт, Улаанчулуутын хогийн цэг дээрх эдийн засгийн, хүрээлэн буй орчны мөн хүн, нийгмийн асуудлуудыг зарим жишээгээр тодруулсан этнографийн ажиглалтуудыг толилуулах болно. Үүнээс гадна, бид цахилгаан шүүлтүүрийн үнс болон үнсэн сангийн үнсийг бетон, геополимер, шилэн керамикийн үйлдвэрлэлд ашиглах боломжийн талаар дурдах болно. Нүүрсийг түлш болгон ашигладаг дулааны цахилгаан станцаас хаягдал үнс их хэмжээгээр гардаг нь байгаль орчин, ард иргэдийн эрүүл мэндэд эрсдэл учруулдаг. Иймд үнсийг байгальд ээлтэй аргаар боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг судлах нь улс орны тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн зайлшгүй ажил юм.

11:40 - 12:20: Элизабет Фокс (Кембрижийн их сургууль), С. Энхбат (Кембрижийн их сургууль)

**Монгол махны стандартыг танилцуулах нь: Дэлхийн мах үйлдвэрлэлийн асуудлыг шийдвэрлэх нүүдэлчдийн шийдэл буюу Монгол Улс мах үйлдвэрлэлийн талаар дэлхийд юу зааж чадах вэ?**

Дэлхий даяар махны эрэлт нэмэгдэхийн хэрээр аж үйлдвэржсэн мах үйлдвэрлэлийн системд амьтдыг хэрхэн үржүүлж, ашиглаж буйд санаа зовних болсон. Ёс зүй, тогтвортой байдал, эрүүл мэнд, цаг уурын нөлөөллийн асуултууд нь махыг ихээхэн чухал бүтээгдэхүүн болгодог боловч хоёрдмол утгатай хүнсний бүтээгдэхүүн болгодог. Энэхүү илтгэлд хэзээд нэгэн төрлийн амттай байдаг дэлхийн мах үйлдвэрлэлийн асуудалд Монгол улс юу санал болгож болох талаар өгүүлнэ. Монгол дахь махны бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ олон улсын стандартад нийцүүлэхийг эрэлхийлэхийн оронд Монгол Улс дэлхийд ёс зүйтэй, тогтвортой мах үйлдвэрлэлийн стандартыг бий болгож, түүгээр тэргүүлэх боломжтой гэсэн саналыг дэвшүүлж байна. Энэхүү төсөөллөөр Монголын махны стандарт нь дотоодын төдийгүй олон улсын мах үйлдвэрлэгчдийн хүсэн хүлээдэг гэрчилгээ болох болно. Монголын бэлчээрийн мал аж ахуйн арвин туршлагад тулгуурлан бидний илтгэл Монгол Улсын махны стандарт гэж юу болохыг тоймлон харуулна.

12:20 - 13:00: Эрик Трифт (Виннипегийн их сургууль), Д. Мөнхтамир (НСИСОУХ), С. Мижид (НСИСОУХ)

**“Нүүдэл ээлтэй” ноолуурыг тодорхойлох нь: Ноолууран бүтээгдэхүүний сүлжээн дэх соёлын тогтвортой байдал**

Уламжлалт ноолууран хувцасны маркетинг нь тансаг байдал, дур булаам байдлыг онцлон тэмдэглэдэг байсан бол дэлхийн загварын хандлага одоо тогтвортой байдлыг улам бүр өөрсдийн брэндийн чухал элемент болгон үзэх болжээ. Олон улсын буяны байгууллага, хөгжлийн байгууллагуудтай хамтран эсвэл өөрсдийн нийгмийн хариуцлагын хүрээнд загвар зохион бүтээгчид болон жижиглэн худалдаачид өөрсдийн хувцсаа "тогтвортой ноолуур" гэж баталгаажуулж, зах зээлд гаргахыг оролдох болсон. Ноолуур үйлдвэрлэдэг малчид ч мөн энэхүү үйл явцаар дамжуулан өөрийгөө таниулж, өөрийгөө сайжруулах горимд оролцох хүсэлтэй гэдгээрээ онцлогтой. Монголын малчдын тогтвортой брэндинг болон шошго зэрэг санаачилгыг хэрхэн ойлгож, удирдан чиглүүлэх арга замыг судалсан угсаатны зүйн судалгаагаар бид “тогтвортой ноолуур” хэмээх ойлголт нь бэлчээрийн мал аж ахуйн улс төрийн эдийн засагт нарийн, техникийн ойлголтыг авчирдаг болохыг олж мэдсэн. Нүүдлийн мал аж ахуйн соёлын өв, өвөрмөц байдлыг хамгаалах талаар ихэвчлэн илэрхийлдэг малчдын өөрсдийнх нь улс төрийн санаа зовоосон асуудлыг “соёлын тогтвортой байдал” гэдэг ойлголтоор дамжуулан олон улсын брэнд болгох нь илүү дээр байж болох юм.

**13:00 - 14:00: Үдийн хоол**

**Панел 5: Номадизм соёл урлагт дүрслэгдэх нь: Үзэсгэлэн болон хэлэлцүүлэг**
Чиглүүлэгч: Д. Бум-Очир

14:00 - 15:30: Ц. Уранчимэг (Индианагийн их сургууль), Б. Цэцэнцолмон (Монгол улсын их сургууль), Т. Энхболд (уран бүтээлч), Л. Мөнхцэцэг (уран бүтээлч), Б. Эрдэнэбат (хөгжмийн продюсер)

**Хэлэлцүүлэг: Орчин үеийн Монголын урлагт нүүдэлчдийн дүрслэлд тулгарч буй асуудлууд**

Монголын эзэнт гүрэн, нүүдэлчдийн мал аж ахуйн өв уламжлалаас сэдэвлэсэн уламжлалт дүрслэл, урлагийн илэрхийлэл Монголын орчин үеийн урлагийн бүтээлд ихээхэн нөлөөлсөн байдаг. Сүүлийн жилүүдэд хотжилт хурдацтай нэмэгдэж, Монголын орчин үеийн урлагт өрнөдийн урлагийн нөлөө ихээр нэвтэрч буй нь дэлхийн соёлын олон янз бүхий үзэл санаануудыг Монголын урлаг, дуу хөгжимд тусгах болжээ. Хэдий төрийн дэмжлэгтэйгээр нүүдэлчдийн соёлыг Монголын үндэсний соёлын суурь хэмээн үздэг үзэл санаа давамгайлсан хэвээр байгаа ч өнөө үеийн уран бүтээлчид энэ мэт үзэл суртал, институцийн хэв маяг, нийгмийн нормд баригдахаас илүүтэй өөрийн хувь хүний өвөрмөц онцлогоо илэрхийлэхийг илүүд үзэх болсон байна. Энэхүү хэлэлцүүлгээр бид дүрслэх болон хөгжмийн урлаг дахь бүтээлүүдийг танилцуулж, Т.Энхболд, Л.Мөнхцэцэг зэрэг туршлагатай, залуу уран бүтээлчид болон хөгжмийн продюсер Б.Эрдэнэбатын бүтээлээр дамжуулан орчин үеийн дүрслэх урлаг болон хөгжим дахь Нүүдэлчдийн уран сайхны илэрхийллийн талаар хэлэлцэх болно.

15:30 – 16:45:
**Дугуй ширээний хэлэлцүүлэг: Номадизм ба үүний геополитикийн ач холбогдол**
Чиглүүлэгч: Урадын Э. Булаг

Тимоти Мэй, Дэвид Снит, Л. Мөнх-Эрдэнэ, Д. Бум-Очир, Тынчтыкбек Чороев, И. Бямбабаатар, Кэрол Феррэт, Эрик Трифт, Томас Вайт, Ц.Уранчимэг, Элизабет Фокс

16:45 - 18:15: “Нүүдэлчдийн урлаг” үзэсгэлэн (Цүлтэмийн Уранчимэгийн дэглэлт; Монгол Уран Зургийн Галерей; 08 дугаар сарын 19-21)

**18:30 - 20:00: Илтгэгчдэд зориулсан оройн зоог** (Асиана ресторан, Цэнтрал Таур 3 давхарт)